



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/512

Номгон

Онцгой комиссын үйл ажиллагаанд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.1, 2.1.2, 3 дугаар бүлгийн 3.3, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 133 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 4.1, аймгийн Засаг даргын 2021 оны А/426 дугаар захирамж, Онцгой комиссын 2021 оны 55 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвараас хамгаалах зорилгоор аймгийн Онцгой комиссоос цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан зохион байгуулж, авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд ашиглах 166,600,994 (Нэг зуун жаран зургаан сая зургаан зуун мянга есөн зуун ерэн дөрвөн) төгрөгийн зардлыг Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах хувиарлах ажлын хэсэг (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН




681210183

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 17--
ны өдрийн А/512 дугаар захирамжийн 1 дүгээр



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын зүйл	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6	7
1	Шатахуун	АОК-оос томилогдсон ажлын хэсгийн 8-р сарын 3-наас 8-р сарын 4 хооронд Баянговь суманд ажиллахад шаардагдах шатахууны зардал	литр	199,9	2,160	431,784
2	Уснаас аврах завь, аврах хантааз	Онцгой Байдлын Газарт усны ослын үед үүрэг гүйцэтгэхэд нэн шаардлагтай завь, хувцас хэрэгсэл олгох зардал	ш	1	10,000,000	10,000,000
3	Бичиг хэргийн материалын зардал	Аймгийн Онцгой Комиссын 8-р сарын бичиг хэргийн материалын зардал	ш	1	1,500,000	1,500,000
4	Шатахуун	АОК-оос томилогдсон ажлын хэсгийн Шаргалжуут рашаан сувилалд ажиллахад шаардагдах шатахууны зардал	литр	60,78	2160	131,285
5	Шатахуун		литр	83,21	2500	208,025
6	Масло		литр	1	12,000	12,000
7	Үерийн хамгаалалтын далан	Баянхонгор аймгийн төвийн ундны эх үүсвэрийн гүний худгийн хамгаалалтын 250 метр үерийн далаг засварлах ажлын зардал	төг	1	5,722,500	5,722,500
8	Шатахуун	Аймгийн Онцгой комиссоос Цагдаагийн газарт шатахууны дэмжлжг үзүүлэх зардал	төг	1	1,700,000	1,700,000
9	Хамгаалалтын зардал	3-р сарын 29-өөс 4-р сарын 30-ны хооронд БТСГазарт үүрэг гүйцэтгэсэн Шонхор харуул хамгаалалтын албаны ажилчдын цалингийн зардал	төг	1	1,200,000	1,200,000



10	Засварын зардал	АОК-н тусгаарлан ажиглах байраар ашиглаж байсан нэгдэлчин зочид буудалд хийгдсэн засварын ажлын хөлсний зардал	төг	1	550,000	550,000
11	Засварын зардал	АОК-н тусгаарлан ажиглах байраар ашиглаж байсан нэгдэлчин зочид буудалд хийгдсэн засварын ажлын материалын зардал	төг	1	445,400	445,400
12	Нэг удаагийн амны хаалт	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх зардал	ш	100,000	60	6,000,000
13	Хамгаалах хувцас	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх зардал	ш	4,000	13,500	54,000,000
14	Бээлий	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх зардал	хайр	600	34,500	20,700,000
15	Нүүрний хаалт	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх зардал	ш	3,000	1,500	4,500,000
16	Ариутгалын бодис /Гипохлорт кальци/	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх зардал	кг	6,000	5,500	33,000,000
17	Ариутгалын бодис /Жавелон/	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх зардал	ш	100	85,000	8,500,000
18	Нэг удаагийн халад	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх зардал	ш	6,000	2,500	15,000,000
19	Нэг удаагийн малгай	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх зардал	ш	10,000	100	1,000,000
20	Шатахуун	АОК-ын Улаанбаатар хотод ажиллах ажлын хэсгийн шатахуун	төг	1	500,000	500,000
21	Тээврийн зардал	АОК-т хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисны 3 сарын нөөц бүрдүүлэх тээврийн зардал	төг	1	1,500,000	1,500,000
Нийт дүн						166,600,994

-----oOo-----

